



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2020/1/СТА-УТҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj @audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсонүгийнжагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.13 № 302

танай _____ -ны № _____ -т

“ДОРНОД АЙМАГ ДАХЬ РАДИО
ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭ” УТҮГ-ЫН
ДАРГА О.НАМУУНЗУЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520214



Үүрэг, хариуцлага

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга О.Намуунзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн санхүүгийн төлөвлөгөө батлуулж ажиллах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудитхийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 13-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитадмөрдсөнбодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол улсын Зүүн бүсэд Монголын радиогийн өргөн нэвтрүүлгийг тасралтгүй чанарын өндөр түвшинд дамжуулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Аcoluos” санхүүгийн программ хангамж ашигласан байна.

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд 11 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 130,459.1 мянган төгрөгөөс тооцон 2,609.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,653.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,859.6 мянган төгрөгөөр буюу 0,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	746.9	269.9	477.0
Авлага	0.0	133.2	133.2
Урьдчилж гарсан зардал	0.0	4,500.0	4,500.0
Бараа материал	253,606.1	265,276.7	11,670.6
Үндсэн хөрөнгө	4,748,928.6	4,762,355.0	13,426.4
Хуримтлагдсан элэгдэл	-1,055,379.2	-1,063,772.8	-8,393.6
Нийт хөрөнгө	3,947,902.4	3,968,762.0	20,859.6
Өр төлбөр	10,999.8	10,288.2	-711.6
Төрийн өмч	3,842,662.6	3,842,662.6	0.0
Хуримтлагдсан ашиг	-447,681.8	-447,681.8	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	21,571.2	21,571.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	541,921.8	541,921.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,947,902.4	3,968,762.0	20,859.6

Урьдчилж гарсан зардалдансны үлдэгдэл өссөн нь Элтрүүд ХХК-тай 9,9 сая төгрөгийн өртөгтэй зуух бариулах гэрээ байгуулж, зуухны гүйцэтгэл 50 хувь хүрсэн тул гэрээнд заасны дагуу 4,5 сая төгрөгийг санхүүжилт шилжүүлснийг бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аймгийн Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-аас даргын ширээ, уулзалтын ширээ, хуруугаар бүртгэх машин гэх мэт бараа материалыг шилжүүлэн өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-аас фургон автомашин шилжүүлэн өгснөөс шалтгаалсан байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн нь 3,968,762.0 мянган төгрөг болж 20,859.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгад тайланд онд бичилт хийгдээгүй байна.



2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 17,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,400.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагч нь 299,319.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 261,392.1 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорилхэрэгжүүллээ.,

Аудитаар нийт 18,290.8 мянган төгрөгийн алдаа, 2,690.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15,600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөхөөр тогтов.

1. Нягтлан бодогч О.Солонго нь “хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх шаардлагатай болсон тул “Хамтын гэрээ”-ний 2.2.3 дахь заалтын дагуу нэг удаагийн тэтгэмж 2,690,800 төгрөгийг олгох тухай” өргөдөл гаргасан байна. Дээрх өргөдлийг үндэслэн нэг удаагийн тэтгэмж олгохдоо *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 15,600.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Иргэн Д.Үл-Олдох нь Радио телевизийн сүлжээний газраас 2019.05.15 өдөр бүтэц орон тооны өөрчлөлтөөр ажлаас халагдсан тул “Нийгмийн даатгалын сан”-ийн “Ажилгүйдлийн тэтгэмжийн сан”-аас ажилгүйдлийн тэтгэмж авсан бөгөөд 2019.07.01-ний өдөр “Мэдээлэл холбооны газар”-т ажилд орсон байна. Иймд Нийгмийн даатгалын сангийн нэгтгэсэн аудитад дахин нягтлан шалгахаар шилжүүлбэ.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ 2019 оны 1,2 дугаар улирлын мэдээллээ байршуулсан боловч 3,4 дүгээр улирлын мэдээлэл байршуулаагүй



байна. Иймд “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-ийн аудит гүйцэтгэж буй нийцлийн аудитын багт шилжүүлье.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онуудад санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаж байгаагүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн төлөвлөгөөний талаар

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд 17,000.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдсанаас 1,400.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 82,3 хувиар тасарсан байна. Жил бүрийн төсвийн төсөлд орлогын төлөвлөгөөг үндэслэлийн дагуу төлөвлөж хүргүүлдэг боловч төсөв батлахдаа үндэслэлгүй үндсэн үйл ажиллагааны орлого хэт өндөр батлагдсанаас шалтгаалж өмнөх онуудад ч тус орлого тасарч байсан байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн байгууллагын төлөвлөсөн хэвийн үйл ажиллагаа алдагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	254 353 090,55	270 179 945,48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	746 958,24	269 949,50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	746 958,24	269 949,50
3121	Төгрөг	746 958,24	269 949,50
31211	Төрийн сангийн харилцах	746 958,24	269 949,50
33	АВЛАГА	00,00	133 286,00
335	Бусад авлага	00,00	133 286,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00,00	133 286,00
34	УРЬДЧИЛГАА	00,00	4 500 000,00
3471	Урьдчилгаа тооцоо	00,00	4 500 000,00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	00,00	4 500 000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	253 606 132,31	265 276 709,98
354	Хангамжийн материал	253 606 132,31	265 276 709,98
35410	Бичиг хэргийн материал	1 125 858,33	1 152 500,00
35420	Аж ахуйн материал	1 193 367,98	726 318,98
35430	Сэлбэг хэрэгсэл	244 307 011,00	253 423 931,00
35440	Түлш, шатах тослох материал	00,00	888 920,00
35450	Барилгын засварын материал	00,00	60 800,00
35460	Хүнсний материал	125 336,00	00,00
35470	Бусад хангамжийн материал	6 854 559,00	9 024 240,00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	3 693 549 385,51	3 698 582 082,27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 693 549 385,51	3 698 582 082,27
391	Газар	00,00	00,00
392	Биет хөрөнгө	689 549 385,51	694 582 082,27
39201	Барилга, байгууламж, орон сууц	647 942 448,50	647 942 448,50
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-21 742 883,40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41 500 000,00	49 436 934,20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38 108 333,17	-19 051 025,73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1 031 903 512,00	1 033 028 612,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-998 238 780,68	-1 004 113 617,08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20 282 177,00	24 646 541,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15 731 638,14	-15 564 927,22
393	Биет бус хөрөнгө	3 004 000 000,00	3 004 000 000,00
39301	Програм хангамж	3 300 480,00	3 300 480,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3 300 480,00	-3 300 480,00
39303	Бусад биет бус хөрөнгө	3 004 000 000,00	3 004 000 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3 947 902 476,06	3 968 762 027,75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10 999 839,00	10 288 210,60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10 999 839,00	10 288 210,60
413	Өглөг	10 999 839,00	10 288 210,60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9 488 819,00	6 802 548,60
4136	Бусад өглөг	1 511 020,00	3 485 662,00
41361	Байгууллагад төлөх өглөг	1 511 020,00	3 480 662,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00,00	5 000,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3 936 902 637,06	3 958 473 817,15
51	Засгийн газрын хувь оролцоо	3 936 902 637,06	3 958 473 817,15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3 842 662 643,85	3 842 662 643,85
51101	Өмч: - төрийн	3 842 662 643,85	3 842 662 643,85
512	Хуримтлагдсан үр дүн	-447 681 766,54	-425 999 410,45
51210	Өмнөх үеийн үр дүн	-447 681 766,54	-447 570 590,54
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	21 571 180,09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	541 921 759,75	541 810 583,75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 947 902 476,06	3 968 762 027,75



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	189 464 423,02	304 265 287,76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	297 823,02	1 542 253,56
120	Нийтлэг татварын бус орлого	297 823,02	1 542 253,56
120002	Хүүгийн орлого	97 823,02	142 253,56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200 000,00	1 400 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200 000,00	1 400 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	189 166 600,00	302 723 034,20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	189 166 600,00	271 786 100,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172 551 600,00	264 997 900,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	16 615 000,00	6 788 200,00
1330	Төсвийн захирагчдаас	00,00	30 936 934,20
133003	Хөрөнгийн	00,00	30 936 934,20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	130 459 111,43	282 694 107,67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130 459 111,43	282 694 107,67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128 664 111,43	275 717 107,67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	81 483 966,00	158 593 965,00
210101	Үндсэн цалин	81 483 966,00	158 593 965,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9 893 274,00	20 037 681,90
210201	Тэтгэврийн даатгал	6 595 521,00	13 685 277,30
210202	Тэтгэмжийн даатгал	824 439,00	1 574 066,82
210203	ҮОМШӨ-ний даатгал	659 549,00	1 300 332,08
210204	Ажилгүйдлийн даатгал	164 887,00	379 777,37
210205	Эрүүл мэндийн даатгал	1 648 878,00	3 098 228,33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 154 327,00	24 062 679,00
210301	Гэрэл, цахилгаан	7 039 447,00	17 588 219,00
210302	Түлш, халаалт	4 114 880,00	6 188 460,00
210304	Байрны түрээс	00,00	286 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 997 296,00	10 623 600,33
210401	Бичиг хэрэг	377 816,00	210 406,33
210402	Тээвэр, шатахуун	4 593 510,00	7 345 228,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670 722,00	1 418 185,00
210404	Ном, хэвлэл	37 500,00	00,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	317 748,00	1 649 781,00
2105	Нормативт зардал	1 086 860,00	936 136,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 086 860,00	936 136,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	617 620,00	8 667 620,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00,00	196 200,00
210604	Урсгал засвар	617 620,00	8 471 420,00
2107	Томилолт, зочны зардал	1 402 150,00	3 861 520,00
210702	Дотоод албан томилолт	1 402 150,00	3 861 520,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 633 442,00	16 304 568,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2 362 050,00	7 127 716,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2 666 592,00	7 967 252,00
210807	Газрын төлбөр	604 800,00	1 209 600,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11 395 176,43	32 629 337,44
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11 395 176,43	32 629 337,44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 795 000,00	6 977 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 795 000,00	6 977 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 795 000,00	6 977 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	59 005 311,59	21 571 180,09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	59 005 311,59	21 571 180,09



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	172 849 423,02	266 540 153,56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	297 823,02	1 542 253,56
120	Нийтлэг татварын бус орлого	297 823,02	1 542 253,56
120002	Хүүгийн орлого	97 823,02	142 253,56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200 000,00	1 400 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200 000,00	1 400 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	172 551 600,00	264 997 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	172 551 600,00	264 997 900,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172 551 600,00	264 997 900,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	172 081 040,80	261 392 062,51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172 081 040,80	261 392 062,51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170 329 040,80	254 451 062,51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83 876 378,00	160 368 125,12
210101	Үндсэн цалин	83 876 378,00	160 368 125,12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11 361 752,00	21 496 983,89
210201	Тэтгэврийн даатгал	7 530 009,00	14 531 334,42
210202	Тэтгэмжийн даатгал	931 237,00	1 743 860,62
210203	ҮОМШӨ-ний даатгал	793 047,00	1 384 472,45
210204	Ажилгүйдлийн даатгал	191 587,00	412 442,06
210205	Эрүүл мэндийн даатгал	1 915 872,00	3 424 874,34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 308 327,00	19 730 903,00
210301	Гэрэл, цахилгаан	8 835 087,00	17 260 143,00
210302	Түлш, халаалт	2 473 240,00	2 184 760,00
210304	Байрны түрээс	00,00	286 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 689 122,00	13 100 021,00
210401	Бичиг хэрэг	283 518,00	245 148,00
210402	Тээвэр, шатахуун	4 346 460,00	10 431 328,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	670 722,00	1 418 185,00
210404	Ном, хэвлэл	61 800,00	00,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	326 622,00	1 005 360,00
2105	Нормативт зардал	415 700,00	955 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	415 700,00	955 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50 529 449,40	18 506 859,90
210604	Урсгал засвар	50 529 449,40	18 506 859,90
2107	Томилолт, зочны зардал	1 649 200,00	3 861 520,00
210702	Дотоод албан томилолт	1 649 200,00	3 861 520,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5 499 112,40	16 431 649,60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2 361 050,00	7 126 716,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2 533 262,40	8 095 333,60
210807	Газрын төлбөр	604 800,00	1 209 600,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 752 000,00	6 941 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 752 000,00	6 941 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 752 000,00	6 941 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	768 382,22	5 148 091,05
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00,00	5 625 100,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00,00	5 625 100,00
2200	Дотоод эх үүсвэрээр	00,00	5 625 100,00
222001	Тоног төхөөрөмж	00,00	4 500 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00,00	1 125 100,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00,00	-5 625 100,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	768 382,22	-477 008,95
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	673 776,88	746 958,24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1 442 159,10	269 949,29



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	838 662 643,85	111 396 128,20	-497 453 859,49	00,00	452 604 912,56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	838 662 643,85	111 396 128,20	-497 453 859,49	00,00	452 604 912,56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	59 005 311,59	00,00	59 005 311,59
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 842 662 643,85	541 921 759,75	-447 681 766,54	00,00	3 936 902 637,06
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 842 662 643,85	541 921 759,75	-447 681 766,54	00,00	3 936 902 637,06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	111 176,00	00,00	111 176,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3 842 662 643,85	541 921 759,75	-447 570 590,54	00,00	3 937 013 813,06
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	-111 176,00	00,00	00,00	-111 176,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	21 571 180,09	00,00	21 571 180,09
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 842 662 643,85	541 810 583,75	-425 999 410,45	00,00	3 958 473 817,15